

ТӨСӨЛ

МОНГОЛ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

(Шилэн дансны мэдээлэл тавих цахим хуудас)

Шилэн дансны тухай хуулийн 5.4 дэх хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 30.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Шилэн дансы цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг хэрэгжүүлж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМ ХУУДСАНД ТАВИГДАХ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА НИЙТЛЭГ СТАНДАРТЫГ ТОГТООХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасан байгууллага нь хуульд заасан мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх нийтлэг стандарт шаардлага, агуулгыг тогтоох, түүнтэй холбогдон гарах эрх зүйн харилцааг зохицуулахад оршино.

1.2. Шилэн дансны тухай хуулийн 3.3-д заасан Төрийн нууцад хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал энэ журамд хамаарахгүй.

Хоёр. Мэдээллийг олон нийтэд түгээхэд баримтлах зарчим

2.1. Мэдээлэл нь иргэд, олон нийтэд нээлттэй байх бүхий л боломжит арга хэрэгслээр хангагдсан байх.

2.2. Мэдээлэл нь Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуульд нийцсэн байх.

2.3. Байгууллага бүр өөрийн цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн цэстэй байх.

2.4 Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 2016 оны 6 дугаар сарын 30-ны дотор шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсыг ажиллуулах.

2.5. Мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх.

Гурав. Төсвийн байгууллага мэдээлэл тавих агуулга, хэлбэр

3.1. Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-т заасан байгууллага дараах агуулга бүхий мэдээллийг дор дурьдсан хэлбэрээр дурьдсан хугацаанд нийтэд мэдээллэнэ:

3.1.1. эрх бүхий байгууллагад өргөн мэдүүлэгдсэн тухайн жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хавсралт 1–д заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар,

3.1.2. жилийн төсөв, орлого, урсгал зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хавсралт 2–т заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар,

3.1.3. хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалтыг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хавсралт 3–т заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар,

3.1.4. улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргааг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хавсралт 4–т заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар,

3.1.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ журмын 3.1.1-д тодорхойлсон үзүүлэлт, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын хагас жилийн үзүүлэлтийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор Хавсралт 1–д заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар,

3.1.6. Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулан, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор Хавсралт 2–д заасан маягтын дагуу цахимаар,

3.1.7. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хавсралт 5–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

3.1.8. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хавсралт 6–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

3.1.9. хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл/тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг/-ийг тендерийн хорооны дүгнэлт гарсанаас хойш 7 хоногийн дотор Хавсралт 7–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

3.1.10. Хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр сар бүрийн 08-ны өдрийн дотор Хавсралт 3–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

3.1.11. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг 7 хоногийн дотор Хавсралт 8–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

3.1.12. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр 7 хоногийн дотор Хавсралт 9–д заасан маягтын дагуу цахимаар, PDF, EXCEL, XML форматаар,

3.1.13. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Хавсралт 10–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

3.1.14. Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг арга хэмжээ тус бүрээр сар бүрийн 08-ны өдрийн дотор Хавсралт 11–д заасан маягтын дагуу цахимаар, PDF, EXCEL, XML форматаар,

3.1.15. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг Хавсралт 2–т заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар,

3.1.16. Шилэн дансны тухай хуулийн 6.4.2, 6.4.6, 6.4.7, 6.4.9-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор тухайн шийдвэрийг цахим хуудсандаа PDF, EXCEL, XML форматаар байршуулна.

3.2. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах агуулга бүхий мэдээллийг дор дурьдсан хэлбэрээр дурдсан хугацаанд нийтэд мэдээллэнэ.

3.2.1. Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийг хагас жилийн байдлаар тухайн жилийн 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар дараа жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 15-ны өдрийн дотор PDF, EXCEL, XML форматаар,

3.2.2. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээг дараа сарын 15-ны дотор Хавсралт 12–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

3.2.3. Засгийн газрын гадаад, дотоод өрийн улирлын мэдээллийг дараа сарын 15-ны дотор Хавсралт 13–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

3.2.4. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны улирлын мэдээллийг дараа сарын 15-ны дотор Хавсралт 14–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

3.2.5. Улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр word форматаар, төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа жилийн 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор холбогдох эрхийн актын хуулбарыг PDF, EXCEL, XML форматаар.

3.2.6. концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас нь хойш долоо хоногийн дотор PDF, EXCEL, XML форматаар

3.2.7. концессын гэрээ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулагдсанаас нь хойш долоо хоногийн дотор хавсралт 15-д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар

3.2.8. концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг долоо хоногийн дотор Хавсралт 15–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар

3.2.9. Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны улирлын мэдээллийг дараа сарын 15-ны дотор Хавсралт 12–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар

3.2.10. Улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлтүүдтэй уялдуулсан судалгаа, тооцооллын улирлын мэдээллийг дараа сарын 15-ны дотор PDF, EXCEL, XML форматаар

3.4. Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсанд байрлуулан тухай бүр шинэчилж Хавсралт 16–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар мэдээлнэ.

Дөрөв. Төрийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанийн мэдээлэл тавих агуулга, хэлбэр

4.1. Төрийн өмчит үйлдвэрийн газар дараах агуулга бүхий мэдээллийг дор дурьдсан хэлбэрээр дурдсан хугацаанд нийтэд мэдээллэнэ.

4.1.1. Шилэн дансны тухай хуулийн 6.2.1-6.2.3, 6.2.5, 6.2.6-д заасан мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хавсралт 17–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

4.1.2. Шилэн дансны тухай хуулийн 6.3.1-6.3.3-д заасан мэдээллийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор Хавсралт 17–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

4.1.3. Өмнөх оны цалингийн төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хавсралт 5–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар.

4.1.4. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хавсралт 6–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар.

4.1.5. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл/тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг/-ийг тендерийн хорооны дүгнэлт гарсанаас хойш 7 хоногийн дотор Хавсралт 7–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

4.1.6. Хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр сар бүрийн 08-ны өдрийн дотор Хавсралт 3–д заасан маягтын дагуу,

4.1.7. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт болон байгууллагын батлагдсан орон тоонд өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор Хавсралт 17-д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

4.1.8. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн хамт худалдан авалт хийснээс хойш 7 хоногийн дотор Хавсралт 8–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML цахимаар

4.1.9. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр тухайн гүйлгээ гарснаас хойш 7 хоногийн дотор Хавсралт 9–д заасан маягтын дагуу цахимаар,

4.1.10. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Хавсралт 10–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

4.1.11. ШДТХуулийн 6.4.9-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор тухайн шийдвэрийг PDF, EXCEL, XML форматаар байршуулна.

4.2. Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани дараах агуулга бүхий мэдээллийг дор дурьдсан хэлбэрээр дурдсан хугацаанд нийтэд мэдээллэнэ.

4.2.1. Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэл, концесс, Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэрийн мэдээллийг өөрчлөлт орсноос 7 хоногийн дотор Хавсралт 10-т заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

4.2.2. Худалдан авах ажтллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг тендерийн хорооны дүгнэлт гарсанаас хойш 7 хоногийн дотор Хавсралт 7–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар,

4.2.3. Төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалтын мэдээллийг 7 хоногийн дотор Хавсралт 18–д заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар байршуулна.

Тав. Аж ахуй нэгж, байгууллага мэдээлэл тавих

5.1. Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг улирал бүр Хавсралт 19-д заасан маягтын дагуу мэдээлэх үүргийг хүлээнэ.

Зургаа. Шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудас

6.1 Шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсыг Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн хариуцан ажиллуулна.

6.2 Байгууллага бүр уг системд хандах өөрийн нэр, нууц үгтэй байх ба шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд оруулах үүрэг хүлээнэ.

6.4 Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа Санхүүгийн програм, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн систем, Төсвийн төлөвлөлтийн систем, Засгийн газрын сангүүгийн удирдлагын мэдээллийн систем, Төсвийн хөрөнгө оруулалтын систем, Зээл тусламжийн систем, Худалдан авах ажиллагааны удирдлагын системүүд нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зохих маягтын дагуу цахим хэлбэрээр мэдээлэл дамжуулах боломжтой байна.

6.5 Шилэн дансны тухай хуулийн 3.1-д заасан байгууллагууд 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших шилэн дансны мэдээллээ PDF, EXCEL, XML форматаар цахимаар архивлан Шилэн дансны нэгдсэн цахим хуудас ашиглалтад ороход системд оруулна.

Долоо. Үүрэг, хариуцлага

7.1. Шилэн дансны мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтан хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлэх үүргийг хүлээнэ.

7.2. Шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5-д заасан зарлагын гүйлгээнд ашиг сонирхлын зөрчил үүссэн гэж үзсэн тохиолдолд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу мэдэгдэж, тухай бүрд нь PDF, EXCEL, XML форматаар нийтэд мэдээллэнэ.

7.3. Энэхүү журмыг зөрчсөн холбогдох албан тушаалтанд Төрийн албаны тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Төсвийн тухай болон Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хариуцлага ногдуулна.

оОо